



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 06 дугаар сарын 17
№23 (1319)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

287.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай	1441
288.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1444
289.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1448
290.	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1449
291.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1450
292.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1453
293.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1454
294.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	1455
295.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1456
296.	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1457
297.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	1460
298.	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/	1461

299.	Ургамал хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1500
300.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1501
301.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1503
302.	Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1504
303.	Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1506
304.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1507
305.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1509
306.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1511
307.	Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1513
308.	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1514
309.	Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/	1518
310.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	1534
311.	Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	1535
312.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1537
313.	Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай	1541

314.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1542
315.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		1544
316.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		1545
317.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		1546
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
318.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай	Дугаар 34	1547
319.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 50	1566
320.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 51	1568
321.	Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 52	1570
322.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 54	1572
323.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 55	1573
324.	Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай	Дугаар 56	1575
325.	Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай	Дугаар 59	1577

326.	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай	Дугаар 61	1578
327.	Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 62	1580
328.	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай	Дугаар 64	1587
329.	Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 68	1635
330.	“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 70	1639



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	6.5	6.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	4.0	3.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	29,400.1	31,951.2	34,460.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.9	30.5	29.5
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	31,300.4	33,521.8	35,628.1
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.9	32.0	30.5
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	3,939.9	2,221.4	2,106.3
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.1	2.1	1.8
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,900.3	-1,570.6	-1,167.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-1.5	-1.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	7,273.3	7,564.2	7,866.8
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	7.7	7.2	6.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	47,507.1	47,117.6	46,708.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	45.0	40.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,850.4	2,931.8	3,269.6
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.0	2.8	2.8

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.13 дахь хэсэг нэмсүгэй:

“32.13.Цахимаар хуралдаанд бүртгүүлсэн бол санал хураахаас бусад асуудалд Хурлын ирцэд оруулан тооцож болно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсгийн “20 өрх тутмаас” гэсний дараа “, аймгийн төв, 20 мянгаас дээш хүн ам бүхий хот, суурин газрын иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 50 өрх тутмаас” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсэг:

“32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.”

Тайлбар:-Энэ хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2/51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг:

“51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь дараах асуудлыг хэлэлцэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж болно.



51.2.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авах шуурхай арга хэмжээ;

51.2.2.нийтийн эрүүл мэнд, тээвэр, ундны ус, бэлчээрийн ашиглалт, хамгаалалт зэрэг хүн амын тулгамдсан асуудал;

51.2.3.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас урьдчилан эрх олгосон бусад асуудал;

51.2.4.энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.”

3/56 дугаар зүйлийн 56.4.1 дэх заалт:

“56.4.1.хорооны Засаг даргад дээд, багийн Засаг даргад бүрэн дундаас дээш боловсролтой;”

4 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйл, 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтын “бүтээгдэхүүн хуваах” гэсний дараа “гэрээ болон Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5.3-т заасан” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folio_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ
ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 37, 38, 39 дэх хэсэг нэмсүгэй:

“37.Нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлагыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал хугацааны дотор нэвтрүүлсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

38.Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

39.Нэгээс илүү сувагтай радио, телевиз нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг нэгээс илүү сувгаар нэвтрүүлсэн бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16.5 дахь заалтын “амлалт өгсөн” гэсний дараа “, эсхүл тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэхээр зарласан” гэж, мөн зүйлийн 16.7 дахь заалтын “байгуулсан” гэсний дараа “, нийтэлсэн, нэвтрүүлсэн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23 дахь хэсгийн “Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг” гэснийг “Хандив өгөхийг хуулиар хориглосон этгээдээс хандив өгсөн бол, тус хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө буцаан шилжүүлээгүй бол, эсхүл хуульд зааснаас илүү хэмжээний хандивыг тухайн сонгуулийн дүн гарахаас өмнө” гэж, мөн зүйлийн 30.2 дахь заалтын “саналаа болон бусад сонгогчийн тэмдэглэсэн саналыг баримтжуулан” гэснийг “санал, саналын хуудасны” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 20 дахь хэсгийн “, эсхүл сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “17.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9, 10, 11, 12, 13, 15 дахь хэсэг” гэснийг “17.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9, 11, 12, 13, 15, 17, 20 дахь хэсэг” гэж, мөн зүйлийн 6.50 дахь заалтын “17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт” гэснийг “17.1 дүгээр зүйлийн 14, 37, 38, 39 дэх хэсэгт” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “17.1 дүгээр зүйлийн 7,” гэснийг “17.1 дүгээр зүйлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улс

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Төрийн захиргааны тусгай зөвшөөрлийн бүсэд байрлах Монгол Улсын Их Хурлын даргын газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2. Сонгуулийн автоматжуулсан системийг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд хэрэглэх талаар гаргасан энэ хуулийн 6.1.1-д заасан шийдвэрийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд мөн адил хэрэглэнэ.”

2/14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэг:

“14.4. Мэдээллийн технологийн төвийн саналыг үндэслэн мэдээллийн технологийн даамлын орон тооны дээд хязгаарыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

14.5. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь мэдээллийн технологийн багийн саналыг үндэслэн энэ хуулийн 14.4-т заасан орон тооны хязгаарт багтаан мэдээллийн технологийн даамлыг томилно.”

3/21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэг:

“21.6. Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийг стандартын шаардлага хангасан, Төрийн хамгаалалттай байранд хадгална.”

2 дугаар зүйл. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “ашиглахтай холбогдон шаардагдах” гэснийг “ашиглах, аюулгүй байдлыг хангахад шаардагдах” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Төрийн албаны тухай хуульд заасан ажиллах нөхцөл баталгаагаар хангагдана” гэснийг “албан хаагчийг томилохдоо тагнуулын байгууллагаас санал авна” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “нийслэлийн” гэснийг “сум, нийслэл, дүүргийн” гэж, “5” гэснийг “7” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “төвийн” гэснийг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Идэвхтэй Файл_02 Н001

Урьдчилсан гэрээний үндсэн дээр 2024 оны 05 сарын 16-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ЭНД ХУУЛЬ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр 2024 оны 05 сарын 16-ны өдөр
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР
ЭНД ХУУЛЬ ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ

Урьдчилсан гэрээний үндсэн дээр

2024 оны 05 сарын 16-ны өдөр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ургамлын эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад оршино.

2 дугаар зүйл.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль тогтоомж

2.1.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Тариалангийн тухай хууль², Байгалийн ургамлын тухай хууль³, Ойн тухай хууль⁴, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль⁵, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль⁶, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Тариалангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

³ Байгалийн ургамлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Ойн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

3.1.Энэ хууль ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, түүнтэй тэмцэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт, экспорт, ре-экспорт, дамжин өнгөрөх асуудлыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ургамал” гэж байгалийн болон таримал бүх төрлийн ургамал, түүний үр, бусад ургал эрхтнийг;

4.1.2.“ургамлын гаралтай бүтээгдэхүүн” гэж ургамлын боловсруулаагүй түүхий эд болон шинж чанар, боловсруулалтын онцлогоос хамаарч хөнөөлт организм нэвтрэх, тархах эрсдэлийг үүсгэж болзошгүй бүтээгдэхүүнийг;

4.1.3.“хөнөөлт организм” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хөнөөл учруулдаг ургамал, амьтны, эсхүл эмгэг төрүүлэгчийн аливаа зүйл, омог, биологийн төрөл, зүйлийг;

4.1.4.“хорио цээртэй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт илрээгүй боловч хил дамнан орж ирж аюул учруулж болзошгүй, эсхүл илэрсэн ч өргөн тархаагүй, эрсдэл, нөлөөллийг бууруулах арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол учруулж болзошгүй нь тогтоогдсон хөнөөлт организмыг;

4.1.5.“гоц хөнөөлт организм” гэж энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй болох нь тогтоогдсон хорио цээртэй хөнөөлт организмыг;

4.1.6.“зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт өргөн тархсан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга нь тодорхой, энэ хуулийн 4.1.12-т заасан эрсдэлийн шинжилгээгээр эдийн засгийн хохирол багатай нь тогтоогдсон хөнөөлт организмыг;

4.1.7.“ургамлын эрүүл мэнд” гэж ургамлын хөнөөлт организмгүй байдлыг;



4.1.8. “ургамлын эрүүл мэндийг хамгаалах” гэж ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийн хор хөнөөлийг бууруулах, хөнөөлт организмгүй байдлыг тогтоох цогц үйл ажиллагааг;

4.1.9. “ургамлын эрүүл ахуйн үзлэг” гэж улсын байцаагчаас ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зохицуулалттай эд, материалд хөнөөлт организм байгаа эсэх болон эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.10. “зохицуулалттай эд, материал” гэж хөнөөлт организмыг тээх, эсхүл дамжин тархаах эрсдэлтэй ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдаалахад ашиглах сав, баглаа боодол, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, хөрс, өөр бусад организм зэрэг ургамлын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай бүх төрлийн эд материалыг;

4.1.11. “ургамал хамгаалал” гэж ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хамгаалах зорилгоор хөнөөлт организмыг илрүүлэх, гаралт, тархалтыг хязгаарлах, тэмцэх үйл ажиллагааг;

4.1.12. “эрсдэлийн шинжилгээ” гэж тухайн илэрсэн организмыг биологийн болон бусад шинжлэх ухааны судалгаа, эдийн засгийн тооцоонд үндэслэн эдийн засаг, байгаль, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хөнөөлийн түвшин, түүний эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.13. “хорио цээртэй хөнөөлт организмгүй газар нутаг” гэж хөнөөлт организмгүй болохыг тандан судалж тогтоох, хянах, тэмцэх, устгах арга хэмжээ хэрэгжүүлдэг болохыг эрх бүхий байгууллагаас тодорхойлсон газар нутаг, эсхүл зарим хэсэг нутгийг;

4.1.14. “мэргэжлийн байгууллага” гэж хөнөөлт организм гарсан, тархсан тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх аж ахуйн нэгжийг;

4.1.15. “ургамал хамгааллын бүтээгдэхүүн” гэж хөнөөлт организмтай тэмцэхэд хэрэглэх химийн болон биологийн гаралтай бүтээгдэхүүнийг.

5 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх;
5.1.2. хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээнд суурилсан байх;

5.1.3. хүн, амьтан, хүрээлэн байгаа орчинд хамгийн бага эрсдэлтэй тэмцэх аргыг хэрэглэж, пестицидийн хэрэглээг бууруулах;

5.1.4. мэдээлэл солилцох болон ил тод, үл ялгаварлах байдлыг хангах;

5.1.5. ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний худалдааны хориг саадыг арилгахад чиглэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УРГАМЛЫН ХӨНӨӨЛТ ОРГАНИЗМ

6 дугаар зүйл. Хөнөөлт организм

6.1. Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан тандан судалгаа хийсний үндсэн дээр хөнөөлт организмыг доор дурдсанаар ангилж, тэдгээрийн жагсаалтыг батална:

6.1.1. хорио цээртэй хөнөөлт организм;

6.1.2. зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организм.

6.2. Хорио цээртэй хөнөөлт организмын жагсаалтад тухайн хөнөөлт организм нь гоц хөнөөлтэй эсэхийг тэмдэглэнэ.

6.3. Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хадгалах, үржүүлэх, тараахыг хориглоно.

6.4. Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.

7 дугаар зүйл. Хорио цээртэй хөнөөлт организмыг мэдэгдэх, баталгаажуулах

7.1. Хорио цээртэй хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл холбогдох этгээд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

7.2. Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсны дараа хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн эд зүйл, нутаг дэвсгэрээс дээж авч, шаардлагатай тохиолдолд лабораторид хүргүүлэх, шинжилгээний дүгнэлтэд үндэслэн албан ёсоор баталгаажуулна.

7.3. Энэ хуулийн 7.2-т заасан баталгаажуулах үйл явцтай зэрэгцэн хорио цээртэй хөнөөлт организм тархах эрсдэлийг арилгах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан этгээд ургамлын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг авна.

7.4. Хорио цээртэй хөнөөлт организмыг энэ хуулийн 7.2-т заасны дагуу албан ёсоор баталгаажуулсан тохиолдолд энэ хуулийн 21.1-д заасан албан тушаалтан нийтэд болон олон улсын холбогдох байгууллагад мэдээлнэ.

8 дугаар зүйл. Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ

8.1. Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд тархахаас сэргийлэх зорилгоор доор дурдсан этгээд энэ хуулийн 6.4-т заасан зааврын дагуу хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн хяналтын доор шуурхай хариу арга хэмжээг авна:

8.1.1. тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, үтрэм, ил талбай, зоорь, агуулахад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч;

8.1.2. бэлчээр, хадлангийн болон ойн сан бүхий газар, ногоон байгууламжид тухайн шатны Засаг дарга.

8.2. Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага илэрсэн хорио цээртэй хөнөөлт организм тархахаас сэргийлэх арга хэмжээний мэдээллийг энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд оруулна.

8.3. Хорио цээртэй хөнөөлт организмтай болох нь тогтоогдсон бол ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон зохицуулалттай эд, материалыг холбогдох этгээд зах зээлээс нэн даруй татах, шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

9 дүгээр зүйл. Хорио цээр тогтоох, мэдээлэх

9.1. Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд доор дурдсан албан тушаалтан, байгууллага голомтын бүсийн хилийн зааг болон хорио цээрийг тогтоож, цуцална:



9.1.1.хорио цээртэй хөнөөлт организмын тархалт нэг сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан, эсхүл хөнөөлт организмын голомтыг нэгтгэх нөхцөл үүсээгүй бол тухайн орон нутаг дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга;

9.1.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан бол тухайн орон нутаг дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга;

9.1.3.төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол хяналт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын салбарын улсын ерөнхий байцаагчийн дүгнэлт, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.

9.2.Хорио цээр тогтоох үйл ажиллагаанд энэ хуулийн 19.1.4-т заасан журмыг баримтална.

9.3.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, тэдгээртэй холбогдон гарах зардлыг баталж, биелэлтэд хяналт тавина.

9.4.Бүх шатны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт хорио цээр тогтоосон тухай шийдвэрээ ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нийтэд зарлан мэдээлнэ.

9.5.Засгийн газрын шийдвэрээр хорио цээр тогтоосон бол ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийтэд зарлан мэдээлнэ.

10 дугаар зүйл.Хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрөл, зүйлээс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг байршуулна.

10.2.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тухайн шатны Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулна:

10.2.1.хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах;

10.2.2.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, орох, гарах хяналтын цэг, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийлгэх;

10.2.3.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах.

10.3.Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах зардлыг энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан тухайн шатны Засаг дарга, 9.1.3-т зааснаар хорио цээр тогтоох тохиолдолд Засгийн газар шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл.Ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийх

11.1.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа мэргэжлийн байгууллага нь хөнөөлт организмын төрөл, зүйлд тохируулан энэ хуулийн 6.4-т заасан зааврын дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал хийнэ.

11.2.Ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хөнөөлт организмын голомт бүхий талбай, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, хүлэмж, үтрэм, ил талбай, зоорь, агуулах, бусад зориулалтын хэрэгсэл, голомтод орсон хүний хувцас, хэрэгсэл, эд зүйлсэд хийнэ.

12 дугаар зүйл.Хорио цээрийг сунгах, цуцлах

12.1.Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хорио цээрийг сунгах, эсхүл цуцлах тухай дүгнэлт, саналыг хорио цээр тогтоосон албан тушаалтан, байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

12.2.Хорио цээрийг сунгасан, цуцалсан бол энэ хуулийн 19.1.4-т заасан журмын дагуу ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нийтэд зарлан мэдээлнэ.

13 дугаар зүйл.Хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгаа

13.1.Хорио цээртэй хөнөөлт организмын илрэх цаг хугацаанд эрсдэлийн шинжилгээнд суурилан тандан судалгааг хийнэ.

13.2.Хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн, эсхүл хөнөөлт организмын шинж тэмдэг илэрсэн бүх байршилд тандан судалгааг хийнэ.

13.3.Хөнөөлт организмын тандан судалгаанд шинжлэх ухаан болон технологийн нотлох баримт, бусад шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг ашиглана.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан байршилд тандан судалгааг 5-7 жилийн хугацаанд үргэлжлүүлэн хийнэ.

13.5.Тандан судалгааны өмнөх оны тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээллийн сангаар дамжуулан тайлагнана.

13.6.Тандан судалгаа хийх аргачлал, эрсдэлийн шинжилгээ хийх зааврыг хийхэд холбогдох стандартыг баримтална.

14 дүгээр зүйл.Гоц хөнөөлт организмын бэлэн байдлын төлөвлөгөө

14.1.Энэ хуулийн 6.2-т заасан гоц хөнөөлт организм тус бүрээр бэлэн байдлын төлөвлөгөөг хүнс, хөдөө аж ахуйн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

14.2.Бэлэн байдлын төлөвлөгөөг гоц хөнөөлт организмын сэжигтэй тохиолдол илэрсэн, албан ёсоор баталгаажсан тохиолдолд ашиглана.

14.3.Бэлэн байдлын төлөвлөгөө доор дурдсан агуулгатай байна:

14.3.1.удирдлага, зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зарлан мэдээлэх;

14.3.2.илэрсэн гоц хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтын хүрээг тогтоох, үнэлэх, хязгаарлах, устгах;

14.3.3.хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт, хөдөлгөөний хяналт, хорио цээр, хязгаарлалтын дэглэм;

14.3.4.ургамлын эрүүл ахуйн үзлэг хийх, дээж авах, лабораторийн шинжилгээ хийх арга зүй;



14.3.5.цаашид шаардлагатай хамгийн бага нөөцийг тодорхойлох;

14.3.6.ариутгал, халдваргүйжүүлэлт, устгал;

14.3.7.нийтэд зориулсан мэдээлэл, сургалт.

14.4.Биологи болон эзэн төрөл зүйл нь төстэй хэд хэдэн гоц хөнөөлт организмын бэлэн байдлын төлөвлөгөөг нэгтгэж гаргаж болно. Энэ тохиолдолд бэлэн байдлын төлөвлөгөө нь тэдгээр хөнөөлт организмын нийтлэг болон онцлог шинжид тохирсон тусгайлсан хэсэгтэй байна.

Тайлбар: “эзэн төрөл зүйл” гэж тухайн хөнөөлт организмд өртдөг ургамлын төрөл, зүйлийг ойлгоно.

14.5.Энэ хуулийн 6.1.1-д заасан жагсаалтад шинээр гоц хөнөөлт организм нэмэгдсэн тохиолдолд жагсаалтад орсноос хойш 1 жилийн дотор түүнтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг батална.

14.6.Бэлэн байдлын төлөвлөгөөг баталсан тухай бүр холбогдох байгууллагад мэдээлнэ.

14.7.Гоц хөнөөлт организмтай тэмцэх нарийвчилсан төлөвлөгөөг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан холбогдох этгээдэд хүргүүлнэ.

14.8.Нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

14.9.Нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавьж ажиллана.

15 дугаар зүйл.Хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг тодорхойлох

15.1.Тандан судалгааны дүнг үндэслэн хорио цээртэй хөнөөлт организмгүй байдлыг аймаг, нийслэлийн хэмжээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сум, дүүрэг, аж ахуйн нэгжийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоож, цуцална.

15.2.Хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутагт тавих шаардлага, газар нутгийг тогтоох, цуцлах журмыг Олон улсын ургамал хамгааллын конвенцын холбогдох стандартад нийцүүлэн хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



16 дугаар зүйл. Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглал

16.1. Зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын тархалтын зураглалыг аймаг, сум, нийслэл, дүүрэг, бүс, улсаар ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргана.

16.2. Тархалтын зураглалыг үндэслэн зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагтаа төлөвлөж хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл. Ургамал хамгаалах цогц арга

17.1. Хөнөөлт организм гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхийн тулд биологи, физик-механик, ургамлын селекци, агротехнологи, химийн аргуудаас дангаар нь, эсхүл хослуулах замаар ургамал хамгаалах цогц аргыг хэрэглэнэ.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан ургамал хамгаалах цогц аргыг хэрэгжүүлэх зөвлөмжийг эрдэм шинжилгээний байгууллага гаргана.

17.3. Хөнөөлт организм гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхдээ ургамал хамгаалах цогц аргыг доор дурдсан байгууллага хариуцан зохион байгуулна:

17.3.1. тариалангийн талбай, түүний ойн зурвас, хүлэмж, үтрэм, ил талбай, зоорь, агуулахад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч;

17.3.2. бэлчээр, хадлангийн болон ойн сан бүхий газар, ногоон байгууламжид тухайн шатны Засаг дарга;

17.3.3. ойд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

18 дугаар зүйл. Ургамал хамгааллын бүтээгдэхүүн

18.1. Хөнөөлт организмтай тэмцэхэд Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрсөн пестицид ашиглаж болно.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан пестицидийг ашиглан ургамлын хөнөөлт организмтай тэмцэх тохиолдолд тухайн пестицидийн нэр, төрөл, хэмжээ, хор аюулын лавлах мэдээлэл, ашиглах зориулалтын талаар үйлдвэрлэгч, эсхүл албан ёсны борлуулагчаас дагалдуулсан, эсхүл эрдэм шинжилгээний байгууллагаас баталсан технологийн зааврыг зөрчихийг хориглоно.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан пестицидийг ашиглан ургамлын хөнөөлт организмтай тэмцсэн талбайд тухайн пестицидийн задралын хугацаа дуусаагүй байхад аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

18.4.Тариалангийн талбай, хүлэмж, зоорь, агуулах, бэлчээр, ойд хөнөөлт организмтай тэмцэхдээ химийн болон цацрагийн аргыг сонгосон тохиолдолд пестицидтэй ажиллах талаарх сургалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан сургалтыг салбарын төрийн бус байгууллага, хуулийн этгээд зохион байгуулж болно.

18.6.Пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдахтай холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

18.7.Пестицидийн хаягдал болон сав, баглаа боодлыг эгүүлэн татах, устгахтай холбогдсон харилцааг Хог хаягдлын тухай⁷ хуулиар зохицуулна.

18.8.Биологийн гаралтай бэлдмэл, ашигт организмыг турших, бүртгэх, ашиглах, импортлох, худалдаалахтай холбогдсон журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.9.Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар⁸ зохицуулна.

18.10.Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд зааснаас гадна доор дурдсан нэмэлт баримт бичгийг тусгай зөвшөөрлийн цахим системд илгээнэ:

18.10.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

18.10.2.эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацааг тодорхой тусгасан өргөдөл;

18.10.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 17.1-д заасан эрсдэлийн үнэлгээний дүгнэлт;

⁷ Хог хаягдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Зөвшөөрлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.



18.10.4.ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг худалдаалах байр, хадгалах агуулахад хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт;

18.10.5.энэ хуулийн 18.10.4-т заасан дүгнэлтээр нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлт;

18.10.6.химийн бодисын сав, баглаа боодлыг устгах, дахин боловсруулах үйлдвэртэй байгуулсан гэрээ;

18.10.7.ургамал хамгаалал, хорио цээрийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшсэн агрономичтой болохыг нотлох дипломын хуулбар, нийгмийн даатгалын лавлагаа.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН
ЧИГ ҮҮРЭГ

19 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

19.1.Засгийн газар ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зохицуулалттай эд, материалыг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг тогтоох;

19.1.2.улсын хилийн боомт дээр ургамлын хорио цээрийн лаборатори, байгууламж, ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн орон нутагт ургамлын хорио цээрийн лаборатори бүхий байнгын ажиллагаатай хорио цээрийн хяналтын цэг байгуулах;

19.1.3.энэ хуульд заасны дагуу хорио цээр тогтоох, цуцлах;

19.1.4.ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг батлах;

19.1.5.гадаад улс, олон улсын холбогдох байгууллагатай ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах;

19.1.6.хуульд заасан бусад.

20 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

20.1.Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.Засгийн газрын эрх олгосноор гадаад улс, олон улсын байгууллагатай ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;

20.1.2.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, ургамал хамгааллын салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

20.1.3.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаарх хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулах;

20.1.4.салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах.

21 дүгээр зүйл.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

21.1.Олон улсын ургамал хамгааллын конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллана.

21.2.Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангах;

21.2.2.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалалтай холбоотой олон улсыг хамарсан цахим системд нэгдэх, харилцан мэдээлэл солилцох;

21.2.3.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран зохион байгуулах;



21.2.4.ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, дүгнэлт гаргах;
21.2.5.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, урьдчилан сэргийлэх болон тэмцэх арга хэмжээний талаар холбогдох этгээдэд мэдээлэх;

21.2.6.Тариалангийн тухай хуулийн 23.3-т заасан мэдээллийн сангийн дэд сан болох ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын цахим санг бүрдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах;

21.2.7.хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ хийх;
21.2.8.хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгааг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэх;

21.2.9.хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутгийг энэ хуулийн 15.2-т заасан журмын дагуу тогтоох;

21.2.10.экспортлох ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд ургамлын хорио цээрийн гэрчилгээг импортлогч орны шаардлагад нийцүүлэн олгох;

21.2.11.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 26.4-т заасан эрх бүхий албан тушаалтны дүгнэлтийг үндэслэн ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулахаас өмнө импортын мэдэгдэл олгох;

21.2.12.ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

21.2.13.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагаанд оролцогчдыг бүртгэх;

21.2.14.хуульд заасан бусад.

21.3.Ургамал хамгааллын мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, эрх олгох, бүртгэхтэй холбогдсон журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**22 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

22.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсний дагуу нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх ургамал хамгаалал, хорио цээрийн арга хэмжээ, тэдгээртэй холбогдон гарах зардлыг батлах, биелэлтэд хяналт тавих;

22.1.2.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, олшролтын төлөв байдал, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний талаарх Засаг даргын тайланг хэлэлцэх;

22.1.3.хуульд заасан бусад.

23 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

23.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд харьяалах нутаг дэвсгэртээ хорио цээрийн хяналтын цэг байгуулах;

23.1.2.хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг эзэмшиж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээдийн ургамал, хамгааллын талаар хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

23.1.3.хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд энэ хуульд өөрөөр заагаагүй бол хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ хорио цээр тогтоох, цуцлах;

23.1.4.хуульд заасан бусад.

24 дүгээр зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын бүрэн эрх

24.1.Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, олшролт, хөнөөлийн талаар тандан судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах;



24.1.2.ургамал хамгааллын бүтээгдэхүүний хор аюулын шинж чанар, түүний ургамал, ус, хөрсөн дэх үлдэгдлийг тодорхойлох;

24.1.3.энэ хуулийн 17.1-д заасан ургамал хамгаалах цогц аргыг хэрэгжүүлэх болон ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг турших, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдах талаар зөвлөмж боловсруулах;

24.1.4.ургамлын хөнөөлт организмаас хамгаалах стандарт, технологийн заавар боловсруулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх;

24.1.5.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах.

25 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

25.1.Хүн, хуулийн этгээд нь ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

25.1.1.ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагаас ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авах, хэрэгжүүлэх;

25.1.2.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт, арга хэмжээний талаар тайлбар шаардах, гомдол гаргах;

25.1.3.эзэмшиж, ашиглаж, эсхүл өмчилж байгаа бэлчээр, тариалангийн талбай, хүлэмжид хөнөөлт организмын гэнэтийн олшролт илэрвэл тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт нэн даруй мэдэгдэх;

25.1.4.ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хураах, савлах, тээвэрлэх, хадгалах, худалдах тохиолдолд Тариалангийн тухай хуулийн 23.3-т заасан мэдээллийн сангаас бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ



26 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын мэдээллийн сан

26.1. Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/ бүрдүүлж, хэвийн үйл ажиллагааг хангана.

26.2. Мэдээллийн санд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага болон холбогдох бусад этгээд мэдээлэл оруулах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

26.3. Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.4. Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь нийтэд нээлттэй байна.

27 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны санхүүжилт

27.1. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс болон хүн, хуулийн этгээдээс санхүүжүүлнэ.

27.2. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

27.2.1. хорио цээртэй болон гоц хөнөөлт организмын тандан судалгаа хийх зардал;

27.2.2. бэлчээрийн хөнөөлт организмтай тэмцэх ургамал хамгааллын бүтээгдэхүүний зардал;

27.2.3. хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн тохиолдолд түүнтэй тэмцэх арга хэмжээний зардал;

27.2.4. энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санг бүрдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах зардал.

27.3. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааны дараах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

27.3.1. бэлчээр дэх ургамалд хөнөөлт организм тархаж, хөнөөл учруулах үед түүнтэй тэмцэх арга хэмжээний зардал;

27.3.2.энэ хуулийн 10.1-д заасан хяналтын цэгийн үйл ажиллагааны зардал;

27.3.3.зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмын жагсаалтад орсон хөнөөлт организмын гаралт, тархалт нь эдийн засгийн хөнөөлийн босгоос давсан үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр голомтыг устгах, хяналтад авах арга хэмжээний зардал.

27.4.Тариалангийн талбай болон хүлэмжид ургамлын хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээд хариуцна.

27.5.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын үйл ажиллагааг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹⁰, эсхүл Зөрчлийн тухай хуульд¹¹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

⁹ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



3.6.6.1. sz. melléklet. A kézikönyvben a tantervben meghatározott tantervi követelmények és a tantervben meghatározott tantervi követelmények közötti különbségek megnevezése.

3.6.6.2. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.3. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.4. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.5. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.6. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.7. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.8. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.9. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.

3.6.6.10. sz. melléklet. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése. A tantervben meghatározott tantervi követelmények megnevezése.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.4 дэх заалт нэмсүгэй:

“17.1.4.ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд пестицид, бордооны үлдэгдлийн хяналтын төлөвлөгөө батлах.”

2 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “турших,” гэсний дараа “бүртгэх,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас” гэснийг “хөнөөлт организмаас” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Голд Ог Нөйл

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠭᠣᠯᠠᠭ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмсүгэй:

“9. Ургамлын эрүүл мэндийг хамгаалах, хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, тэмцэх, устгахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж” гэснийг “хөнөөлт организм” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас” гэснийг “хөнөөлт организмаас” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтын “өвчин, хортон, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж, мөн зүйлийн 25.1.7 дахь заалтын “арга хэмжээг” гэснийг “аргыг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын дарга

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.24 дэх заалт:

“20.1.24.ургамлын зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ.”

2/27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалт:

“27.5.26.ургамлын хорио цээртэй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ,”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалтын дугаарыг “27.5.27” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

“6.Албан ёсны сорилт, туршилт, шинжлэх ухаан, сургалтын зорилгоор сорт сонгох, бүтээхэд ашиглахаас бусад тохиолдолд хөнөөлт организмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн, нүүлгэн шилжүүлсэн, хадгалсан, үржүүлсэн, тараасан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 3.5 дахь заалтын “хэрэглэх” гэсний дараа “заавар,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай” гэснийг “хөнөөлт организмтай” гэж, 2 дахь хэсгийн “Ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн, эсхүл бусад үйл ажиллагаа явуулж ургамал, хорио цээрийн дэглэм” гэснийг “Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журмыг” гэж, 3 дахь хэсгийн “бодис” гэснийг “бүтээгдэхүүн” гэж, мөн хэсгийн 3.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдаалах” гэж, 4 дэх хэсгийн болон 13.1 дүгээр зүйлийн 3.2 дахь заалтын “өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.65 дахь заалт нэмсүгэй:

“6.65.таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 10.27, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “5.11 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 6.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт, 2, 3, 4, 5, 7, 10 дахь хэсэг, 7.8,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь заалтын “13.2 дугаар зүйл,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



Мэдээлэл_на Нөхцөл

Хэргийн үндэслэл

2024 оны 11 сар 20 - өдөр

Хэргийн үндэслэл
Хэргийн үндэслэл

Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл:

2024.06.06. Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...»

Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...»

Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...»

Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл... Хэргийн үндэслэл...
Хэргийн үндэслэл...»

Хэргийн үндэслэл
Хэргийн үндэслэл



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.6 дахь заалтын “ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах” гэснийг “ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг импортлох, худалдаалах” гэж, “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын
Дарга

Хууль /2024 оны 06 сарын 05 өдөр /

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА

Хууль /2024 оны 06 сарын 05 өдөр /
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА

Хууль /2024 оны 06 сарын 05 өдөр /
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.5 дахь хэсэг нэмсүгэй:

“5.5. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Генетик нөөцийн тухай,” гэсний дараа “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.8. мал, амьтны гоц халдварт өвчин /цаашид “амьтны гоц халдварт өвчин” гэх/, ургамлын хорио цээртэй хөнөөлт организм /цаашид “ургамлын хорио цээртэй зүйл” гэх/ илэрсэн тохиолдолд тухайн хилийн боомт, гүний гаальд хорио цээр тогтоох саналыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран Засгийн газарт оруулах, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хянах;”

4 дүгээр зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гадаад



хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчний халдвар, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хорио цээртэй хөнөөлт организм” гэж, мөн заалтын “эрүүл мэндийн” гэснийг “эрүүл мэнд, ургамал хамгааллын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “байгууллага” гэсний өмнөх “хорио цээрийн” гэснийг “эрх бүхий” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

1 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:

№	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Архангай аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Эрүү, давж Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорноговь аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дорнод аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Дундговь аймгийн Иргэний хэргийн заалдах шатны шүүх	Эрүү, давж Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



12	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
23	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
24	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
25	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Хоёр.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Гурав.Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



2 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:

№	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хотын Налайх дүүрэг	Нийслэлийн Багахангай, Налайх дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хотын Багануур дүүрэг	Нийслэлийн Багануур дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хотын Налайх дүүрэг	Нийслэлийн Багахангай, Налайх дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хотын Багануур дүүрэг	Нийслэлийн Багануур дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Гурав.Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх			
1	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



Дөрөв.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх			
1	Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Тав.Захиргааны хэргийн анхан шатны шүүх			
1	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



13	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Зургаа.Аймаг дахь анхан шатны шүүх			
1	Архангай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завханмандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд
12	Орхон аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



19	Ховд аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд
Долоо.Сум дундын шүүх			
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	Дорноговь аймаг, Замын-Үүд сум	Дорноговь аймгийн Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд сумд
2	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	Завхан аймаг, Тосонцэнгэл сум	Завхан аймгийн Тэс, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Их-Уул, Тосонцэнгэл сумд
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	Өмнөговь аймаг, Ханбогд сум	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Цогтцэций, Ханбогд сумд
4	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	Өвөрхангай аймаг, Хархорин сум	Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Есөнзүйл, Өлзийт, Бүрд, Баян-Өндөр сумд
5	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумд
6	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	Сэлэнгэ аймаг, Сайхан сум	Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Сайхан сумд
7	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	Ховд аймаг, Булган сум	Ховд аймгийн Булган, Алтай, Үенч, Цэцэг, Мөст сумд
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	Хэнтий аймаг, Бор-Өндөр сум	Хэнтий аймгийн Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумд
<p>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</p> <p style="text-align: right;">Г.ЗАНДАНШАТАР</p>			



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Gol_02.html

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠠᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ

ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ

ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ
ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ

ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ
ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ

ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ

ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠤᠰᠢᠨᠠᠭ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсэгт заасан анхан шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.

2 дугаар зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болмогц шүүгчийг анхан болон давж заалдах шатны шүүхэд шилжүүлэн томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

3 дугаар зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсэгт заасан анхан болон давж заалдах шатны шүүхэд шүүгчийг томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4 дүгээр зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл. Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.6, 32.7 дахь хэсэг нэмсүгэй:

“32.6.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-т заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогдсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана.

32.7.Энэ хуулийн 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй.”

2 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалтын “давж заалдах шатны” гэсний өмнө “анхан болон” гэж, мөн зүйлийн 25.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “тухайн шүүхийн Зөвлөгөөний” гэсний дараа “, эсхүл Ерөнхий зөвлөлийн” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “томилж болно.” гэсний дараа “Шүүгч тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй нэг гэр бүл, төрөл садангийн холбоотой болохоо Ерөнхий зөвлөлд мэдэгдсэн, эсхүл тухайн шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад хуульч бүртгүүлээгүй, шалгалтад тэнцээгүй, томилогдоогүй, сэлгэн ажиллах захиалгаар шүүгч хүсэлт ирүүлээгүй, зохист ачааллаас илүү ачаалалтай ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдсон бол дөрвөөс дээш жил ажилласан шүүгчийн зөвшөөрлийг үндэслэн адил шатны өөр шүүхэд шилжүүлэн томилуулах саналыг Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид хүргүүлж болно.” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэг:

“43.4.Энэ хуулийн 43.1, 43.3-т заасан үндэслэлээр шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.”

2/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:



“46.3.Ерөнхий зөвлөл шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээг өөрийн батлагдсан төсвийн хүрээнд тогтоож, нэмэгдэл олгох журмыг батална. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоог Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.”

3/71 дүгээр зүйлийн 71.1.3 дахь заалт:

“71.1.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоог тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд уламжлах.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсгийн “, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан” гэснийг, мөн зүйлийн 89.2 дахь хэсгийн “хууль зүйн магистраас дээш зэрэгтэй,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

“13.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ганилцуулахаар” гэсний дараа “мэдэгдэх хуудсаар” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хэргийг” гэснийг “Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хэргийг” гэж, 14.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “үндэслэлийг шүүхэд” гэснийг “хууль зүйн үндэслэл, түүний нотлох баримтыг шүүх, шүүхийн хэлэлцүүлэгт оролцогчид” гэж, 31.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Баривчлагдсан сэжигтэн” гэснийг “Сэжигтэн” гэж, 31.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Баривчлагдсан өсвөр насны” гэснийг “Өсвөр насны” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсгийн “хүлээж авна.” гэсний дараа “Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй.” гэж, 185 дугаар зүйлийн 185.1 дэх хэсгийн “хүлээн авна.” гэсний дараа “Холбогдох этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн авахад саад болохгүй.” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Идэвхтэй Файл - 02 Н011

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠭᠣᠯᠢ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ

ᠰᠢᠭᠡᠬᠡ ᠰᠢᠬᠡᠳᠡᠭᠡᠬᠡ ᠲᠤᠬᠤ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 11 дэх хэсэг нэмсүгэй:

“11.Энэ хуульд заасан эрүүгийн хэргийн шүүхийн анхан шатны журмаар харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын
Мэдээлэл

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/

Хууль /2024.06.05/ - 05 - 06 /2024.06.05/



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.6 дахь хэсэг нэмсүгэй:

“13.6.Энэ хуульд заасан тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэлийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх харьяалан шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Идэвхтэй Файл_02 НЭМЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”-ыг 1 дүгээр, “Нэгжийн өөрчлөлтийн төслийн үндсэн мэдээлэл”-ийг 2 дугаар, “Саналын хуудас”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian State Court

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙГ ӨӨРЧЛӨХ АСУУДЛААР ИРГЭДИЙН САНАЛ АВАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүрэг /цаашид “нэгж” гэх/-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах, иргэдийн санал авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг баримтална.

Хоёр.Нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“нэгжийг өөрчлөх” гэж тухайн орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан улс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинээр байгуулах, нийлүүлэх, хуваах, шилжүүлэх, татан буулгах зэргээр харьяалал, нэр, нутаг дэвсгэрийн хэмжээ, хилийн цэсийг шинэчлэн тогтоох, иргэний бүртгэл, кадастрын зургийн бүртгэл, хаягийн хөдөлгөөн хийх үйл ажиллагааг;

2.1.2.“нэгжийг шинээр байгуулах” гэж тухайн орон нутагт иргэдийн суурьшил эрчимтэй нэмэгдсэн байдлыг үндэслэн зэргэлдээх нэг буюу түүнээс дээш нэгжийн нутаг дэвсгэрээс хуваан олгох замаар нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд шинэ нэгж байгуулахыг;

2.1.3.“нэгжийг нийлүүлэх” гэж хоёр болон түүнээс дээш нэгжийн үйл ажиллагааг зогсоон нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд нэгтгэж, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон нэгжид шилжүүлэхийг;



2.1.4.“нэгжийг хуваах” гэж нэгжийн үйл ажиллагааг зогсоож, түүний нутаг дэвсгэр болон эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсэх хоёр болон түүнээс дээш нэгжид олгохыг;

2.1.5.“нэгжийг шилжүүлэх” гэж тухайн нэгжийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөхийг;

2.1.6.“нэгжийг татан буулгах” гэж бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж тухайн нэгжийн үйл ажиллагааг зогсоохыг;

2.1.7.“нэгжийн өөрчлөлтийн төсөл” гэж өөрчлөлтөд хамрагдах нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нутаг дэвсгэр, хилийн цэс, хүн ам, газар зүйн байршил, эдийн засгийн бүтэц, төрийн болон нийтийн үйлчилгээний хүртээмж зэргийг тусгасан баримт бичгийг.

Гурав.Нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим

3.1.Нэгжийг өөрчлөх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.1.1.байгаль, газар зүйн онцлог, орон зайн байршил, алслалыг харгалзах;

3.1.2.нутаг дэвсгэр давхцахгүй байх;

3.1.3.орон нутгийн иргэдийг оролцуулах;

3.1.4.угсаатны онцлог, өв соёлыг хамгаалах;

3.1.5.нийгэм, эдийн засгийн үр ашигтай байх.

Дөрөв.Нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах

4.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.2-т заасны дагуу аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

4.2.Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, өөрчлөлтөд хамрагдах нэгжийн Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулна.

4.3.Нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулахад дараах нөхцөлийг харгалзан үзэж, төслийн баримт бичигт тусгана:

4.3.1.харьяалах нэгжийн тоо, харьцаа ойролцоо байх;

4.3.2.байгаль, газар зүйн онцлог, алслал болон нутаг дэвсгэрийн хэмжээ зохистой, тэнцвэртэй байх, хилийн цэс тодорхой байх;



4.3.3.хүн амын өсөлт, суурьшил, шилжих хөдөлгөөний хандлагыг тооцсон байх;

4.3.4.зам, тээвэр, эрчим хүчний хангамж, усан хангамж, ариутгах татуургын систем зохих стандартын дагуу байх;

4.3.5.иргэдэд чиглэсэн төрийн болон орон нутгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшнээс дээшилсэн байх;

4.3.6.бусад.

4.4.Энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан мэдээллийг баримт бичигт тусгана.

4.5.Нэгжийн өөрчлөлтийн төсөл, төсвийг боловсруулахад холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага чиг үүргийн дагуу оролцож, уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулна.

4.6.Монгол Улсын хил дагуух сумыг өөрчлөхтэй холбоотой асуудлаар Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газрын саналыг авна.

Тав.Иргэдийн санал авах үйл ажиллагаа

5.1.Нэгжийн өөрчлөлтийн төслийг тухайн нэгжийн иргэдэд мэдээлэх, танилцуулах, оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээ хийх, иргэдээс санал авах, дүнг нэгтгэн мэдээлэх ажлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцан зохион байгуулна.

5.2.Нөлөөллийн шинжилгээнд нэгжийг өөрчилснөөр гарах үр дагавар, зардлын талаар иргэд болон холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан саналыг тусгана.

5.3.Энэ журмын 5.1-д заасан арга хэмжээг энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш сум, дүүргийг гурван сар, аймгийг зургаан сарын хугацаанд тус тус багтаан зохион байгуулна.

5.4.Аймгийг өөрчлөх асуудлаар Засгийн газар, сум, дүүргийг өөрчлөх асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.



5.5. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжийг өөрчлөх асуудлаар урьдчилан тогтоосон байранд, битүүмжилсэн саналын хайрцаг ашиглан нууц санал хураалт явуулна.

5.6. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн саналыг энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан саналын хуудсаар авна.

5.7. Санал хураалтад тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд оролцох бөгөөд иргэдийн олонх оролцсон бол санал хураалтыг хүчинтэйд тооцно.

5.8. Өөрчлөлтөд нэг нэгж хамрагдах тохиолдолд санал хураалтад оролцсон иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.

5.9. Өөрчлөлтөд хоёр ба түүнээс дээш нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.

5.10. Санал хураах үйл ажиллагаанд ажиглалт хийх зорилгоор иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

5.11. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.7-5.9-д заасан санал хураалт дууссаны дараа саналын хуудсыг тоолж, дүнг 24 цагийн дотор харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

5.12. Нэгжийг өөрчлөх асуудлаар явуулсан иргэдийн санал хураалтын дүн, тайланг ажлын 3 өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичиг боловсруулах, иргэдээс санал авах үйл ажиллагаа болон нэгжийг өөрчилсний дараа гарах иргэний болон үл хөдлөх хөрөнгийн, газар зохион байгуулалт, кадастрын зургийн, хаягийн зэрэг улсын бүртгэлийн өөрчлөлтийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.2. Энэ журмыг зөрчсөн аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний төлөөлөгч, ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

НЭГЖИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлт	Өөрчлөлтөд хамрагдах нэг дэх нэгжийн нэр		Өөрчлөлтөд хамрагдах хоёр дахь нэгжийн нэр		Тайлбар
		Одоогийн байдал	Төсөл	Одоогийн байдал	Төсөл	
1.1	Нэгжийн харьяалал /аймаг, дүүрэг/					
1.2	Нэгжийн нэр /сум, дүүрэг/					
1.3	Нэгжийн төлөв /аймгийн төв, ердийн, алслагдсан, хилийн, орон нутгийн хот/					
1.4	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй холбогдох асуудал /өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан/					
1.5	Өөрчлөлтийн төрөл /шинээр байгуулах, татан буулгах, нийлүүлэх, хуваах, шилжүүлэх/					
1.6	Нутаг дэвсгэрийн хэмжээ /га-гаар/					
1.7	Алслагдсан байдал -Улаанбаатар хотоос нэгж хүртэлх зай; -Аймгийн төвөөс сум хүртэлх зай; -Сумын төвөөс багийн төв хүртэлх зай; -Хамгийн ойрхонтатаццлын төв хүртэлх зай.					

1.8	Хилийн цэс, зааг -Аймаг, сум, дүүргийн хилийн цэс, баг, хорооны нутаг дэвсгэрийн зааг, тэдгээрийг тогтоосон баримт /шийдвэр, зураг, цэгийн товчоо/, төсөл /зураг, цэгийн товчоо/, өөрчлөлтийн хэмжээ.							
1.9	Байгаль орчин -Байгалийн бус, голын ай сав, уул нурууд, нөөц, эх үүсвэр; -Байгаль хамгаалах үйл ажиллагаа; -Байгаль орчинд учруулах эрсдэл, түүнээс сэргийлэх.							
2.1	Хүн ам зүй -Хүн амын тоо, ерхийн тоо; -Хүн амын есөлтийн хувь; -Сонгуулийн насны хүний тоо.							
2.2	Шилжих хөдөлгөөн -Шилжин ирэх иргэдийн тоо, хувь; -Гадагш шилжих иргэдийн тоо, хувь; -Татах хүчний онцлог; -Түлхэх хүчний онцлог.							
2.3	Орон нутгийн аж ахуй, үйлдвэрлэл, онцлог /мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, үйлдвэр зэрэг/							
2.4	Өрхийн орлогын гол эх үүсвэр /төрөл тус бүрийн хувь/							
3.1	Зам, тээврийн байдал -Хатуу хучилттай авто зам; -Сайжруулсан авто зам; -Төмөр зам.							

3.2	Эрчим хүчний хангамж -Төвийн эрчим хүч, чадал; -Бусад, чадал.							
3.3	Усан хангамж /Эх үүсвэр, чанар/							
3.4	Цэвэрлэх байгууламж -Ахуйн хатуу хог хаягдлын татан авалт, боловсруулалт; -Бохир усны систем, ариутгал; -Үйлдвэрийн хог хаягдлын татан авалт, боловсруулалт, устгал.							
4.1	Эрүүл мэндийн үйлчилгээ -Үйлчилгээний байгууллага /сум, баг, өрхийн эмнэлэг, түргэн тусламж/; -Хамран үйлчлэх хүрээ; -Үйлчилгээний тоо; -Орон тоо, төсөв.							
4.2	Боловсрол /Мэргэжлийн сургалтын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын, ерөнхий боловсролын сургуулийн тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо/							
4.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх -Цагдаагийн байгууллагын хүчин чадал, орон тоо; -Шүүхийн байгууллагын хамрах тойрог; -Бусад.							

<p>4.4 Нийгмийн бусад үйлчилгээ -Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настны халамжийн үйлчилгээ; -Татвар; -Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал; -Бусад.</p>						
<p>4.5 Төрийн байгууллагын ажил, үйлчилгээтэй холбогдох бүтэц, орон тоо, төсөв /байгууллага тус бүрээр хийж, дүнг нэгтгэнэ/</p>						

Тухайн нэгжийн одоогийн нөхцөл байдал, ирээдүйн төсөөлөл бүхий төслийг холбогдох мэргэжлийн байгууллагууд хийж, ажлын хэсэгт ирүүлэхдээ шаардлагатай нэмэлт материалыг хавсаргана.

---oOo---



Монгол Улсын Их Хурлын 2024 оны
34 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

САНАЛЫН ХУУДАС

..... засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг шинээр
байгуулах, нийлүүлэх, хуваах, шилжүүлэх төслийн талаарх санал:

- а. Дэмжинэ
- б. Дэмжихгүй

.... он ... сар ... өдөр

Тайлбар: Саналын хуудсанд шинээр байгуулах, нийлүүлэх,
хуваах, шилжүүлэхийн аль нэгийг бичнэ.

---oOo---

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Индикс Фолло_ 02 Year Hor& 02 Doc&log&

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн

Ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн
сэргээгч үйлчилгээний үйлдвэр, үйлчилгээний үйлдвэр
болон ажлын үр дүнд үндэсний эдийн засгийн



Үргэлжлэн ажлын үр дүнд үзүүлсэн
дүнд хэргийн үр дүнд үзүүлсэн

Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй

Хүндийн дүнд	Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй		Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй		№
	Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй	Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй	Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй	Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй	
					1.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					2.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					3.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					4.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					5.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					6.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/
					7.0 Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй /Түрээс, дүн үнэмлэхүй, дүн үнэмлэхүй үнэмлэхүй/



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Цэдэвийн Цолмонг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Шилагарьдын Солонгыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Бямбадоржийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Батсүхийн Буяндэлгэрийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Рагчаагийн Батрагчааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Гомбожавын Туулхүүг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолын хавсралтын Улсын ерөнхий прокурорын газар гэсэн баганын “АА-5” зэрэглэлийн “Тасгийн дарга,” гэсний өмнө “Прокурорын газрын хэлтэс,” гэж, “АА-9” зэрэглэлийн “Ахлах мэргэжилтэн” гэсний өмнө “Прокурорын газрын” гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Gol_02 Урд Норг ба Дорнод

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ
ᠤᠯᠤᠰ

ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ

ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ

ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ
ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ

ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ ᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-IVA”-ийн захиргааны албан тушаалд “Төрийн албаны зөвлөлийн дарга” гэж нэмсүгэй.

2.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VA”-ын захиргааны албан тушаалын “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга” гэснийг “, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэж өөрчилсүгэй.

3.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VA”-ын Захиргааны албан тушаалд “Ёс зүйн хорооны дарга” гэж, “ТӨ-VIA”-ийн Захиргааны албан тушаалд “, Ёс зүйн хорооны гишүүн” гэж тус тус нэмсүгэй.

4.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтын адилтгах албан тушаалын зэрэглэлийн “ТӨ-VIA”-ийн захиргааны албан тушаалын “Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрын ангиллыг дээшлүүлэн дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсугай.

2.Булган уулын дархан цаазат газрын хилийн заагийг хавсралтаар баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 1995 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тогтоолын 4 дэх заалтын 1 дэх дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
61 дүгээр тогтоолын хавсралт

БУЛГАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

№	Аймгийн нэр	Уртраг	Өргөрөг	Талбайн хэмжээ /га/
1	Архангай	101° 28' 50.923" E	47° 30' 02.828" N	2,000.12
2		101° 28' 06.346" E	47° 29' 08.103" N	
3		101° 26' 39.884" E	47° 29' 12.154" N	
4		101° 25' 55.087" E	47° 29' 03.310" N	
5		101° 25' 24.710" E	47° 28' 56.361" N	
6		101° 24' 52.822" E	47° 30' 07.978" N	
7		101° 28' 37.739" E	47° 33' 01.150" N	
8		101° 28' 26.808" E	47° 30' 20.846" N	

---oOo---

Индриг Фолг оа Үлд Норг оа Доелг оа

МОНГОЛЫН ХУУЛЬ

Хууль

2024 оны 23 дугаар сарын 13-ны өдөр

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль

МОНГОЛЫН ХУУЛЬ
Хууль



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

**Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар
газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр
олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай
холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт
хийсэнтэй холбогдуулан авах зарим
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх, зориулалтын дагуу ашиглах, албан татвар, төлбөр, хураамж ногдуулах, тайлагнах, хураах үйл ажиллагааг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, чиг үүргийн шинжилгээг хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулан 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зарчимд нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3/Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон талбайд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсэн асуудлыг шалгаж, холбогдох арга хэмжээг авч, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх;



4/Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалалтад авч, бүртгэлийг сайжруулах;

5/хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, улсын тусгай хамгаалалттай газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан асуудлыг судалж, төрийн байгууллагын мэдээлэл зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, мэдээллийн сан хоорондын уялдааг хангах, газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системтэй холбох арга хэмжээг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулах;

6/ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өр үүссэн шалтгааныг судалж, өрийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөгийг яаралтай барагдуулах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7/Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам, ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг шинэчлэн боловсруулах, эдийн засгийн хувьд үр ашигтай дагалдах ашигт малтмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах эрх зүйн орчныг бий болгох;

8/үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувиар ногдуулж байгаа хуулийн заалтад үр дагаврын үнэлгээ хийж, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

9/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өөрчлөгдөхөд төлөх татвар ногдуулах суурийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох;

10/хууль бусаар ашигт малтмал олборлогчийн үйл ажиллагааг таслан зогсоох, эвдрэлд орсон, орхигдсон талбайн байгаль орчинд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх, нөхөн сэргээх, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог сайжруулах;

11/уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, хаасны дараа орон нутагт хүлээлгэж өгөх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх;

12/бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн зохицуулалтын талаар дүн шинжилгээ хийх, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

13/Монгол Улсын нийт газар нутгийн эрдэс баялгийн хэтийн төлөвийг тодорхойлж үнэлэх, зохистой хэрэглээг хянах зорилгоор геологийн суурь судалгааны ажлыг эрчимжүүлэх;

14/Монгол Улсын ашигт малтмалын нөөц, орд, илрэл болон газрын хэвлийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хуульд заасны дагуу шинэчлэх, тухайн ордын ашигт малтмалын нөөцийн үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг олборлолтод бэлтгэсэн байдалд магадлан шинжилгээ хийж, үнэмшлийг тогтоох;

15/уул уурхайн биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

16/Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим нь хуулиар эрх олгоогүй журам, маягт баталж, түүнчлэн уг танхимаас Монгол Улсаас экспортолж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа үйл ажиллагааг таслан зогсоох талаар холбогдох хуулийн төслийг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах.

2.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлээгүй, хууль бусаар газрыг эвдрэлд оруулж, талбайн дүгнэлт гаргуулж, түүнд үндэслэн бичил уурхайгаар ашиглуулж байгаа талаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг холбогдох хуулийн дагуу шалгаж, шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/, Цагдаагийн Ерөнхий газар /Т.Сүхболд/-т тус тус зөвлөсүгэй.

3.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтан, нотлох баримтыг шинжлэн судлах сонгогд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй гэрчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсантай холбогдуулан бүсийн зорилго, зорилтуудыг дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 2001 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоол, Монгол Улсын Их Хурлын “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” 2003 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Төрийн мэдээлэл
Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Индриг Фолд дагд Хорд дагд Доддигд

Төрийн мэдээлэл

Төрийн мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

НЭГ.ЭРХЭМ ЗОРИЛГО

Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ.

ХОЁР.БҮСЧЛЭЛИЙН ТОГТОЛЦОО

2.1.Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлнэ. Бүсэд дараах аймаг, хот хамаарна:

- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг;
- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хойд бүсэд: Булган, Орхон, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Говийн бүсэд: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг;
- Улаанбаатарын бүсэд: нийслэл Улаанбаатар хот ба түүний дагуул хотууд.

2.2.Нийслэл, аймаг бүрд орон нутгийн хөгжлийн төв, тэдгээрт таталцах сум, сууринг дараах байдлаар тогтоох бөгөөд хөгжлийн тухайн үеийн нөхцөл, шаардлагатай уялдуулан өөрчилж болно:



№	Аймаг, хот	Орон нутгийн хөгжлийн төв	Хөгжлийн төвд таталцах сум, суурин
1	Архангай	Эрдэнэбулган	1. Ихтамир
			2. Төвшрүүлэх
			3. Цэнхэр
			4. Булган
			5. Чулуут
			6. Батцэнгэл
		Эрдэнэмандал	1. Хайрхан
			2. Цэцэрлэг
	3. Жаргалант		
	Хотонт	1. Өгийнуур	
		2. Өлзийт	
		3. Хашаат	
	Тариат	1. Өндөр-Улаан	
		2. Цахир	
		3. Хангай	
	Баянхонгор	Баянхонгор	1. Бөмбөгөр
			2. Галуут
			3. Өлзийт
			4. Баян-Овоо
			5. Эрдэнэцогт
Богд		1. Баянлиг	
		2. Жинст	
		3. Баянговь	
Баянцагаан		1. Шинэжинст	
		2. Баацагаан	
		3. Баян-Өндөр	
Жаргалант		1. Заг	
	2. Гурванбулаг		
Бууцагаан	1. Хүрээмарал		
	2. Баянбулаг		
Өвөрхангай	Арвайхээр	1. Тарагт	
		2. Хайрхандулаан	
		3. Зүүнбаян-Улаан	
		4. Нарийнтээл	
		5. Уянга	
	Хархорин	1. Хужирт	
		2. Бат-Өлзий	
	Есөнзүйл	1. Бүрд	
		2. Өлзийт	



2		Сант	1. Баян-Өндөр 2. Баянгол	
		Гучин-Ус	1. Богд 2. Төгрөг 3. Баруунбаян-Улаан	
			Есөнбулаг	1. Дэлгэр 2. Тайшир 3. Шарга
				Тонхил
	Баян-Уул	1. Жаргалан 2. Хөхморьт		
		Бигэр	1. Эрдэнэ 2. Цогт 3. Чандмань	
	Халиун		1. Цээл	
	Төгрөг		1. Бугат	
	Алтай	-		
	Говь-Алтай	Улиастай	1. Идэр 2. Алдархаан 3. Яруу 4. Цагаанхайрхан	
			Шилүүстэй	1. Цагаанчулуут 2. Отгон
				Завханмандал
			Тэс	
		Түдэвтэй		
				Тосонцэнгэл
			Улаангом	
				Өмнөговь
		Зүүнговь		



	Ховд	Баруунтуруун	1. Өндөрхангай 2. Цагаанхайрхан 3. Зүүнхангай		
		Сагил	1. Давст 2. Бөхмөрөн		
		Наранбулаг	1. Завхан		
		Ховд	Ховд	1. Эрдэнэбүрэн 2. Мянгад 3. Буянт 4. Дөргөн 5. Жаргалант 6. Дуут	
				Манхан	1. Чандмань 2. Мөнххайрхан
					Дарви
				Булган	
		Баян-Өлгий			Өлгий
				Дэлүүн	
	Цэнгэл		1. Улаанхус		
	Буянт		1. Алтай		
	Ногооннуур		-		
	3	Булган	Булган	1. Орхон 2. Сайхан 3. Бугат	
				Хутаг-Өндөр	1. Баян-Агт 2. Тэшиг
					Хишиг-Өндөр
			Дашинчилэн	1. Гурванбулаг 2. Баяннуур 3. Рашаант	
				Орхон	Баян-Өндөр



4	Хөвсгөл	Мөрөн	1. Бүрэнтогтох
			2. Түнэл
		Рэнчинлхүмбэ	3. Тосонцэнгэл
			4. Төмөрбулаг
		Хатгал /Алаг-Эрдэнэ/	5. Баянзүрх
			6. Арбулаг
	Тариалан	1. Цагааннуур	
		2. Улаан-Уул	
	Галт	1. Чандмань-Өндөр	
		2. Цагаан-Үүр	
	Цагаан-Уул	3. Ханх	
		1. Их-Уул	
	4	Дархан-Уул	Дархан
3. Эрдэнэбулган			
1. Шинэ-Идэр			
Сэлэнгэ		Сүхбаатар	2. Жаргалант
			1. Цэцэрлэг
			1. Орхон
		Ерөө	2. Хонгор
			3. Шарын гол
			1. Зүүнбүрэн
Сайхан		2. Хушаат	
		3. Шаамар	
		4. Алтанбулаг	
	5. Цагааннуур		
Мандал	6. Түшиг		
	1. Жавхлант		
	2. Хүдэр		
Төв	Зуунмод	1. Орхон	
		2. Орхонтуул	
		3. Баруунбүрэн	
	Угтаалцайдам	4. Сант	
		1. Баянгол	
	Баянчандмань	1. Сэргэлэн	
2. Алтанбулаг			
3. Баян-Өнжүүл			
1. Баянцогт			
Баянчандмань	2. Цээл		
	1. Борнуур		
	2. Жаргалант		
	3. Батсүмбэр		
			4. Сүмбэр



5	Дорнод	Лүн	1. Заамар 2. Баянхангай 3. Аргалант	
		Эрдэнэсант	1. Дэлгэрхаан 2. Бүрэн 3. Өндөрширээт	
		Хэрлэн	1. Сэргэлэн 2. Баянтүмэн 3. Булган	
		Баян-Уул	1. Баяндун 2. Цагаан-Овоо	
		Дашбалбар	1. Гурванзагал 2. Чулуунхороот	
		Халхгол	1. Матад	
	Сүхбаатар	Баруун-Урт	1. Сүхбаатар 2. Уулбаян 3. Эрдэнэцагаан 4. Асгат 5. Халзан 6. Түвшинширээ	
			Онгон	1. Баяндэлгэр 2. Наран 3. Дарьганга
			Мөнххаан	1. Түмэнцогт
			Эрдэнэцагаан	-
	Хэнтий		Хэрлэн	1. Баянхутаг 2. Баянмөнх 3. Мөрөн
			Батноров	1. Норовлин 2. Баян-Овоо
		Биндэр	1. Батширээт 2. Баян-Адрага 3. Дадал	
		Жаргалтхаан	1. Өмнөдэлгэр 2. Цэнхэрмандал 3. Дэлгэрхаан	
		Бор-Өндөр	1. Галшар 2. Дархан	
		Говьсүмбэр	Сүмбэр	1. Баянтал 2. Шивээговь



	Дорноговь	Сайншанд	1. Алтанширээ
			2. Өргөн
			3. Мандах
			4. Сайхандулаан
			5. Дэлгэрэх
		Замын-Үүд	1. Эрдэнэ
			2. Улаанбадрах
		Хатанбулаг	1. Хөвсгөл
	Айраг	1. Иххэт	
		2. Даланжаргалан	
	Дундговь	Сайнцагаан	1. Дэрэн
			2. Дэлгэрцогт
			3. Луус
			4. Хулд
			5. Гурвансайхан
			6. Адаацаг
			7. Өлзийт
		Эрдэнэдалай	1. Сайхан-Овоо
			2. Дэлгэрхангай
	Говь-Угтаал	1. Өндөршил	
2. Баянжаргалан			
3. Цагаандэлгэр			
Өмнөговь	Даланзадгад	1. Ханхонгор	
		2. Цогт-Овоо	
		3. Мандал-Овоо	
		4. Хүрмэн	
		5. Номгон	
		6. Баяндалай	
		7. Булган	
	Гурвантэс	1. Сэврэй	
2. Ноён			
Цогтцэций	1. Манлай		
Ханбогд	1. Баян-Овоо		
7	Улаанбаатар	Багахангай	1. Баян
			2. Баянцагаан
			3. Баянжаргалан
	Багануур	1. Баяндэлгэр	
		2. Архуст	
		3. Мөнгөнморьт	
Налайх	1. Эрдэнэ		

ГУРАВ.БҮСҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго:

-Бүс нутгийн хөгжлийн орчин үеийн онолын чиг хандлагад үндэслэнэ;

-Бүс нутгийн онцлог, давуу талыг нээн илрүүлнэ;

-Бүс, орон нутгийн эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлно;

-Байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээнэ;

-Үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжинэ;

-Бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ;

-Бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

-Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна;

-Татвар, санхүүгийн ялгаатай бодлогыг хэрэгжүүлнэ;

-Бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг дэмжинэ;

-Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлнэ;

-Дэд бүтцийн нэгдсэн, ухаалаг сүлжээг байгуулна;

-Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлийг тэлнэ;

-Орчин үеийн шинэ суурьшлын бүс, хотуудыг байгуулна;

-Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна;

-Орон нутагт ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг хөгжүүлнэ.

3.1.ХАНГАЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн “Дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс” болно.



Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. Орхоны хөндийд нийслэлийн баримжаатай Шинэ Хархорум хотыг байгуулж, засаглалын төвлөрлийг зохицуулна.

3.1.2. Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот-Улиастай хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.1.3. Шинэ Хархорум хотод сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хотхоныг байгуулна.

3.1.4. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Баянхонгор аймагт дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.1.5. Шинэ Хархорум хотод “Орхоны хөндий” өндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулна.

3.1.6. Шинэ Хархорум хотод үндэсний дата төвийн нөөц төв байгуулна.

3.1.7. Шинэ Хархорум хотод улс, хот хоорондын өгөгдөл дамжуулах сүлжээг хянах, удирдах, бүсийн үндсэн сүлжээний зангилаа төв байгуулна.

3.1.8. Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.1.9. Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.1.10. Шинэ Хархорум хотод 4E ангиллын нисэх буудал байгуулна.

3.1.11. Шинэ Хархорум хотод бүсийн тээвэр, логиستيкийн төв байгуулна.

3.1.12. Өвөрхангай аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.1.13. Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн түүх, соёл, рашаан сувиллын аялал жуулчлалыг уламжлалт, сэргээн засах анагаах ухаантай уялдуулан хөгжүүлнэ.



3.1.14.Архангай аймгийн Өгийнуур орчимд археологийн нөөцөд тулгуурлан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

3.1.15.Өвөрхангай аймагт Өндөр гэгээн Занабазарын бүтээл, соёлын өвд тулгуурлан соёлын аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.1.16.Говийн бүсийг усаар хангах “Орхон-Онги” төслийн бүсэд ногдох хэсгийг байгуулна.

3.1.17.Хангайн нурууны байгаль, түүх, соёлын өв бүхий 5.4 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авч, эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.1.18.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.1.19.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.1.20.Өвөрхангай аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамжийн төв байгуулна.

3.1.21.Хангайн бүсэд нүүрс-эрчим хүч, металл боловсруулах үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.1.22.Өвөрхангай аймагт бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

3.1.23.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд түшиглэн эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон уламжлалт анагаах ухаанд суурилсан сувилал байгуулна.

3.1.24.Батцэнгэл сум-Ихтамир сум чиглэлийн авто замыг барина.

3.1.25.Чингис хот-Чойр хот-Мандалговь хот-Арвайхээр хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.1.26.Бага-Илэнх боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.1.27.Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн баруун босоо төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.1.28.Баянхонгор аймагт Байдрагийн 30 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

3.1.29.Цэцэрлэг хот-Баянхонгор хот чиглэлийн авто замыг барина.

3.1.30.Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн өндөр хурдны авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.2.БАРУУН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв Азийн орнууд болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу-Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий “Тогтвортой хөгжлийн бүс” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.2.1.Монгол Алтайн нуруу, Хангайн нуруу, Увс нуурын сав газар, их нууруудын экосистемд түшиглэсэн байгалийн адал явдалт, тусгай сонирхлын, хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ.

3.2.2.Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд Монгол Алтайн нурууны байгаль, соёлын өвд түшиглэсэн эко парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.2.3.Увс, Ховд аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

3.2.4.Ховд аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.2.5.Өлгий хот, Алтай хотод байрлах радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон технологид шилжүүлнэ.

3.2.6.Монгол Алтайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өв бүхий 5.8 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авч, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.

3.2.7.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн



цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.2.8.Ховд хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

3.2.9.Ховд аймагт бүсийн хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.2.10.Говь-Алтай аймагт барилга, уул уурхайн салбарын хэрэгцээг хангах дэвшилтэт технологийн шохойн болон магнетитийн үйлдвэрийг байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.2.11.Ховд аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамжийн төв байгуулна.

3.2.12.Ховд хотод бүсийн дата төв байгуулна.

3.2.13.Ховд аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.2.14.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Ховд, Увс аймагт дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.2.15.Баруун бүсэд нүүрс-эрчим хүч, металл боловсруулах үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.2.16.Ховд аймагт бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

3.2.17.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, зүрх, судасны тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлнэ.

3.2.18.Завхан аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

3.2.19.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.2.20.Говь-Алтай аймагт 15 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц барина.



3.2.21.Улиастай хот-Шинэ Хархорум хот-Улаанбаатар хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.2.22.Ховд аймгийн Ховд гол дээр эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

3.2.23.Эрдэнэбүрэн сум-Мянгад сум-Улиастай хот чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.2.24.Мөрөн хот-Улиастай хот-Алтай хот чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.2.25.Баруун бүсэд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станц барина.

3.2.26.Баруун бүсэд эрчим хүчний нэгдсэн системийн суурь ачаалалд ажиллах 100 МВт хүртэл хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

3.2.27.Завхан аймагт 30 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

3.2.28.Бүсийн тогтвортой хөгжлийг дэмжсэн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх шинэ технологийг нэвтрүүлнэ.

3.2.29.Булган, Арцсуурь, Бургастай боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.2.30.Ховд хотын тээвэр, логистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулна.

3.2.31.Завхан аймгийн Загастайн давааны ар-Ховдын Мянгадын гүүр-Хонгиогийн гүүр чиглэлийн авто замыг барина.

3.2.32.Хөх эрэг-Өлгий хот чиглэлийн авто замыг барина.

3.2.33.Улаангом хот-Ховд хот чиглэлийн авто замыг барина.

3.2.34.Арцсуурь боомт-Баянхайрхан сум-Тэлмэн сум болон Улиастай хот-Алтай хот-Бургастай боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замыг барина.

3.2.35. Мөрөн хот-Улиастай хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.2.36. Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн баруун босоо төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.2.37. Булган боомт-Хөшөөтийн уурхай-баруун босоо төмөр замтай Завхан аймгийн Борхын голын бэлчирт нийлэх чиглэлийн төмөр замыг барина.

3.2.38. Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн өндөр хурдны авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.3.ХОЙД БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан аялал жуулчлал, амралт сувилал, хүнд үйлдвэрлэлээр төрөлжсөн “Аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.3.1. Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

3.3.2. Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.

3.3.3. Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

3.3.4. Хөвсгөл аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.3.5. Эрдэнэт хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

3.3.6. Орхон аймагт зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

3.3.7. Булган аймгийн Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.



3.3.8.Орхон аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.3.9.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Хөвсгөл, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.3.10.Сэлэнгэ мөрний сав газрын усны урсац бүрэлдэх эх, нэн ховор, ховор амьтан ургамал бүхий 3.1 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авна.

3.3.11.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.3.12.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.3.13.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлнэ.

3.3.14.Орхон аймагт бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

3.3.15.Хөвсгөл аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

3.3.16.Мөрөн хотод байрлах радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлнэ.

3.3.17.Мөрөн хотод бүсийн дата төв байгуулна.

3.3.18.Ханх, Бага-Илэнх боомтуудыг өргөжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.3.19.Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.3.20.Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр сум чиглэлийн авто замыг барина.



3.3.21.Ханх боомт-Хатгал тосгон болон Мөрөн хот-Тэлмэн сум чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.3.22.Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.4.ТӨВИЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логиستيкийн нэгдсэн сүлжээнд холбогдож, уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан “Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.4.1.Эрүүл хүнс, түүхий эд бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлнэ.

3.4.2.Төрийн зарим байгууллагыг Хөшигийн хөндийн дагуул хот руу нүүлгэн шилжүүлнэ.

3.4.3.Улаанбаатар хот, Зуунмод хот, нийслэлийн дагуул хотуудын орчмын нутаг дэвсгэрийг хамарсан Туул голын сав, Богдхан уулын экосистемд түшиглэсэн олон улсын арга хэмжээ, хотын аяллыг хөгжүүлэх Хөшигийн хөндийн аялал жуулчлалын тусгай бүс байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.4.4.Хөшигийн хөндийд байгуулах сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг түшиглэн “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.4.5.Хөшигийн хөндийд “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.4.6.Хөшигийн хөндийд бүсийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэр болох дулааны цахилгаан станц барина.

3.4.7.Төв аймгийн Хөшигийн хөндий, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логиستيкийн төв байгуулна.

3.4.8.Төв аймгийн Хөшигийн хөндий, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг чөлөөт бүсийг түшиглэн хуурай боомт байгуулна.

3.4.9.Дархан-Уул аймагт бүсийн хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.4.10.Ойн сан, усны урсац бүрэлдэх эх, нэн ховор, ховор амьтан, ургамлын тархалт бүхий 1.5 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авна.

3.4.11.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.4.12.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.4.13.Дархан-Сэлэнгийн бүсэд металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

3.4.14.Сэлэнгэ аймагт металл бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.4.15.Дархан-Уул аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.4.16.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.4.17.Сэлэнгэ аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

3.4.18.Дархан-Уул аймагт орчин үеийн стандартад нийцсэн нэгдсэн эмнэлэг барина.

3.4.19.Дархан-Уул аймагт улс, хот хоорондын өгөгдөл дамжуулах сүлжээг хянах, удирдах, бүсийн үндсэн сүлжээний зангилаа төв байгуулна.



3.4.20. Дархан-Уул аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.4.21. Багануур хот-Чойр хот чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.

3.4.22. Эрчим хүчний нэгдсэн систем бүрдүүлэгч гол шугам Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот-Улиастай хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.4.23. Төв аймгийн Бөөрөлжүүт-Сэргэлэн сум чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

3.4.24. Төв аймагт Бөөрөлжүүтийн 300 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

3.4.25. Бүсийн эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станц барина.

3.4.26. Сэлэнгэ аймагт 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

3.4.27. Дархан хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

3.4.28. Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.4.29. Алтанбулаг боомт-Дархан хот чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.4.30. Налайх хот-Замын-Үүд хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.4.31. Даланзадгад хот-Мандалговь хот-Улаанбаатар хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.4.32. Төв аймгийн Жаргалант сумын Талбулаг-Сэлэнгэ аймгийн Орхон сумтай холбох авто замыг барина.

3.4.33. Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.4.34.Сүхбаатар хот-Богдхан-Замын-Үүд боомт чиглэлийн хос төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.5.ЗҮҮН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн “Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.5.1.Зүүн бүсэд түүх, соёлын нөөц, экосистемд түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

3.5.2.Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Бурхан халдун, Буйр нуур, Алтан Овоо зэрэг түүхэн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулна.

3.5.3.Сүхбаатар аймгийн Дарьганга суманд байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлд түшиглэсэн байгаль, соёлын өвийн цогцолбор байгуулна.

3.5.4.Дорнод аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

3.5.5.Дорнод аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.5.6.Чойбалсан хотод бүсийн тээвэр логистикийн төв байгуулна.

3.5.7.Зүүн бүсэд кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.5.8.Чойбалсан хот, Бичигт боомтын тээвэр, логистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулна.

3.5.9.Дорнод аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамжийн төв байгуулна.



3.5.10.Тал хээрийн экосистемийн тэнцвэрийг хангах зорилгоор 3.0 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авна.

3.5.11.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.5.12.Дорнод аймагт хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.5.13.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.5.14.Чойбалсан хотод байрлах радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлнэ.

3.5.15.Чойбалсан хотод бүсийн дата төв байгуулна.

3.5.16.Дорнод аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.5.17.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Дорнод аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.5.18.Дорнод аймагт бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

3.5.19.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлнэ.

3.5.20.Хэнтий аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

3.5.21.Говийн бүсийг усаар хангах “Хэрлэн тооно” төслийн бүсэд ногдох хэсгийг байгуулна.

3.5.22.Багануур хот-Чингис хот-Чойбалсан хот-Хавирга боомт чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.



3.5.23.Бүсийн тогтвортой хөгжлийг дэмжсэн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх шинэ технологийг нэвтрүүлнэ.

3.5.24.Эрэнцав, Сүмбэр, Хавирга, Бичигт боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.5.25.Сүмбэр боомт-Түмэнцогт сум чиглэлийн авто замыг барина.

3.5.26.Эрэнцав боомт-Чойбалсан хот-Баруун-Урт хот-Бичигт боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замыг барина.

3.5.27.Чингис хот-Чойр хот-Мандалговь хот-Арвайхээр хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.5.28.Зүүнбаян-Баруун-Урт хот-Сүмбэр боомт чиглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.5.29.Эрэнцав боомт-Чойбалсан хот-Бичигт боомт чиглэлийн төмөр замыг барина.

3.6.ГОВИЙН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлал хөгжсөн “Үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.6.1.Өмнөговь аймагт нүүрс-эрчим хүч болон металлургийн кокс, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

3.6.2.Дорноговь аймгийн Алтанширээт суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна.

3.6.3.Говийн бүсэд хүнд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.6.4.Өмнөговь аймагт Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.



3.6.5.Нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.

3.6.6.Говийн бүсийг усаар хангах “Орхон-Онги”, “Хэрлэн тооно” төслийн бүсэд ногдох хэсгийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.6.7.Дундговь аймгийн Цагаансуварга орчимд палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

3.6.8.Даланзадгад, Чойр хотуудад бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

3.6.9.Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын болгон өргөтгөнө.

3.6.10.Дорноговь аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

3.6.11.Даланзадгад хотод байрлах радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлнэ.

3.6.12.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж, цөлжилтийг бууруулна.

3.6.13.Говийн унаган байгаль, түүх, соёлын өв бүхий 3.0 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авна.

3.6.14.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.

3.6.15.Говьсүмбэр аймагт бүсийн хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.6.16.Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сургийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

3.6.17.Өмнөговь аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

3.6.18.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн



болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Дорноговь аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

3.6.19.Өмнөговь аймагт бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

3.6.20.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлнэ.

3.6.21.Өмнөговь аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

3.6.22.Чойр хотыг логистикийн төв, хуурай боомтод түшиглэн олон улсын худалдааны төв, оёдлын кластерын загвараар хөгжүүлнэ.

3.6.23.Замын-Үүд хотын эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логистикийн төвийг байгуулна.

3.6.24.Сайншанд хотод улс, хот хоорондын өгөгдөл дамжуулах сүлжээг хянах, удирдах, бүсийн үндсэн сүлжээний зангилаа төв байгуулна.

3.6.25.Чойр, Сайншанд хотуудын тээвэр, логистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулна.

3.6.26.Чойр хот-Сайншанд хот чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.

3.6.27.Багануур хот-Чойр хот чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.

3.6.28.Сайншанд хот-Дорноговь аймгийн Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл хийнэ.

3.6.29.Хөрш орнуудад цахилгаан эрчим хүч экспортлох үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.6.30.Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.6.31.Чингис хот-Чойр хот-Мандалговь хот-Арвайхээр хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.6.32.Бага-Илэнх боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.6.33.Налайх хот-Замын-Үүд хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.6.34.Даланзадгад хот-Мандалговь хот-Улаанбаатар хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

3.6.35.Шивээхүрэн боомт-Арцсуурь боомт чиглэлийн баруун босоо төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.6.36.Зүүнбаян-Баруун-Урт хот чиглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.6.37.Цогтцэций сум-Даланзадгад хот-Шивээхүрэн боомт чиглэлийн төмөр замыг барина.

3.6.38.Сүхбаатар боомт-Богдхан-Замын-Үүд боомт чиглэлийн хос төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.6.39.Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн өндөр хурдны авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

3.7.УЛААНБААТАРЫН БҮС

Бүсийн хөгжлийн зорилго нь Төв болон Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ, байгаль орчны зохистой бүтэцтэй, 20 минутын үйлчилгээний хүртээмжтэй төвүүд бүхий хот болж “Олон улсын банк, санхүү, бизнесийн хөгжлийн төв” болно.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.7.1.Олон улсын банк, санхүүгийн үйлчилгээний төвийг хөгжүүлнэ.

3.7.2.“Шинэ Зуунмод” дагуул хотыг аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ.



3.7.3.Иргэд оршин суугаа газраасаа бүх төрлийн суурь үйлчилгээг авах төлөвлөлтийг хэрэгжүүлж, нийслэлийг “20 минутын хот” болгон хөгжүүлнэ.

3.7.4.Худалдаа, үйлчилгээ, их, дээд сургууль, соёл, спортын цогцолборыг нийслэлийн дэд төвүүдэд шилжүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

3.7.5.Улаанбаатарын бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэн, сургалтын дэд бүтэц, салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна.

3.7.6.Багахангай дүүрэгт эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан зах зээлийн эрэлтийг хангах шилний үйлдвэрийг байгуулна.

3.7.7.Толгойт, Шар хад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийг байгуулна.

3.7.8.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг дүүрэг бүрд байгуулна.

3.7.9.Гандантэгчилэн хийд орчмын соёлын орон зайг “Үндэсний соёлын өвийн дурсгалт газар” болгон, шашны аялал жуулчлалын төв болгож хөгжүүлнэ.

3.7.10.Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор байгуулна.

3.7.11.Хэрэглээний биотехнологийн төв байгуулна.

3.7.12.Улаанбаатар хотын ундны ус хангамжийг 80 хувиар нэмэгдүүлэн, шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.

3.7.13.Үндэсний дата төвийн нөөц төвийг Багануур дүүрэгт байгуулна.

3.7.14.Хонхорын радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлнэ.

3.7.15.Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах тархмал дулааны эх үүсвэрийг 9 байршилд барьж, суурилагдсан хүчин чадлыг 595 МВт-аар нэмэгдүүлнэ.

3.7.16.Хотын дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хог, хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх станц барина.



3.7.17.Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудыг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.7.18.Эрчим хүчний нэгдсэн систем бүрдүүлэгч гол шугам Багануур хот-Улаанбаатар хот чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барина.

3.7.19.Багануур хотод 400 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

3.7.20.Улаанбаатар хотод 12 тойрог зам барина.

3.7.21.Олон улсын чанартай “Шинэ тойрог зам”-ыг барьж, хотоор дамжин өнгөрөх ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулан зохицуулна.

3.7.22.“Агросити” эдийн засгийн тусгай бүсийг байгуулна.

3.7.23.Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийг байгуулна.

3.7.24.Багануур хотод хүнд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.

3.7.25.Улаанбаатар хотын зүүн болон баруун бүсэд олон улсын ачаа тээврийн терминал, дэд төвүүдэд хүнсний агуулахыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барина.

3.7.26.Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор байгуулна.

3.7.27.Нийслэл орчмын бүсэд сүү, тахиа, хүлэмжийн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

3.7.28.Улаанбаатар хотод “Биокомбинат”-ыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, өргөтгөнө.

3.7.29.Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын 30 км далан болон ус зайлуулах 100 км суваг шинээр барьж, үер, усны аюул гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

**ДӨРӨВ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗОРИЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

4.1.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- I үе шат: 2024-2030 он;
- II үе шат: 2031-2040 он;
- III үе шат: 2041-2050 он.

ТАВ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭРЭГСЭЛ

5.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтыг нэгдсэн тогтолцоогоор хэрэгжүүлнэ.

5.2.Бүс нутгийн тэргүүлэх чиглэл, байгаль газар зүйн нөхцөл, нөөц, байршлын давуу талтай уялдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна.

5.3.Бүсийн хөгжлийн бодлогод нийцсэн татварын бодлого хэрэгжүүлнэ.

5.4.Аймаг, нийслэл, сумын хот байгуулалтын баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.5.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, улсын болон аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг, сум, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангана.

5.6.Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.7.Орон нутгийн хөгжлийн төвүүдэд тусгай бүс, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр, логистикийн төв, хуурай боомтыг байгуулах хувийн хэвшлийг тэргүүн ээлжид дэмжинэ.

ЗУРГАА.ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН

6.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:



6.1.1.Бүс нутгийн эдийн засаг, нийгмийн тэнцвэрт хөгжлийг хангах, улмаар үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлнэ.

6.1.2.Бүс бие даан хөгжих чадвартай болж, бүс нутгуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний ялгаа багасаж, иргэдийн амьдралын чанарын үзүүлэлт өсөж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурна.

6.1.3.Бүсчлэлээр дамжуулан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоотой, эдийн засгийн үйл ажиллагааны төрөлжилт, дагналт, хоршилт бүхий бүс нутгийг хөгжүүлнэ.

6.1.4.Бүсүүд бие даан хөгжих чадвартай болж, бүс нутгуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшний ялгаа буурна.

6.1.5.Хот, хөдөөгийн иргэдийн амьдралын түвшин, чанарын ялгаа багасна.

6.1.6.Хүн ам суурьшсан нутаг дэвсгэрийн дэд бүтцийн хангамж шаардлагатай түвшинд хүрч, нийлүүлэлтийн сүлжээ бүрдсэнээр нэг төвийн хамаарал арилна.

---oOo---

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
64 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин /он/			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хармуцах байгууллага
				2030	2040	2050				
1.Хангайн бүс										
1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	3.8	3.8	0.8	0.8	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	284	336	342	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



3	Шинээр баригдах төмөр замын урт	км	-	210	223	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	Улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо	тоо	-	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	-	5	9	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

6	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо			1		Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
7	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	330	-		Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
8	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	30	-		Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
2.Баруун бүс											
1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	12.6	4.2	0.8	0.8	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага



2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	742	638	765	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага
3	Шинээр баригдах төмөр замын урт	км	-	725	509	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага
4	Улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо	тоо	-	1	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага

5	Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо	тоо	-	1	1	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	-	15	15	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн тоо	тоо	-	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



8	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
9	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	100	100	Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
10	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	468.3	585	Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
3.Хойд бүс										

1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	3.8	-	146	137	394	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	146	137	394	Шалгуур үзүүлэлт Нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3	Улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо	тоо	-	-	1	-	Шалгуур үзүүлэлт Нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

4	Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	4	7	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

7	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	310	-	Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшингтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
4. Төвийн бүс										
1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	1.8	0.6	0.5	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	116	92.13	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага



3	Шинээр баригдах төмөр замын урт	км	-	116	594	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	5	7	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

6	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	100	50	300	Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	188	-	87.2	Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.Зүүн бүс										
1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	5.1	1.4	0.8	0.8	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	528	710	218	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага
3	Шинээр баригдах төмөр замын урт	км	-	752	645	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага
4	Улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо	тоо	-	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллага

5	Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо	тоо	-	1	2	1	2022 оны суурь түвшин	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр логистикийн төв	тоо	-	-	5	8	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



8	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	-	518	Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.Говийн бүс										
1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	сая.га	5.7	2.4	0.3	2023 оны суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт	км	-	376	685	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

3	Шинээр баригдах төмөр замын урт	км	-	143	249	901	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	Улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо	тоо	-	1	-	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо	тоо	-	1	1	1	2022 оны суурь түвшин	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



6	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	5	7	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	-	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	1	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

9	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	450	-	100	Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
10	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	205	-	408	Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
7. Улаанбаатарын бүс											
1	Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр, логистикийн төв	тоо	-	-	-	2	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага
2	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	-	-	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захирааны төв байгууллага



3	Шинээр байгуулагдах хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн тоо	тоо	-	-	1	Шалгуур үзүүлэлт нь шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлэх бөгөөд өссөн дүнгээр тооцно. Суурь түвшин 0-ээс эхэлнэ.	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
4	Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал	МВт	-	400	595	Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага
5	Цахилгаан дамжуулах шугамын урт	км	-	130	-	Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын урт	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллага

---000---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг санхүүжүүлэх;

2/иргэнд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, зориулалтын шаардлага хангасан шүүхийн барилга байгууламж шинээр барихтай холбоотой төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг авах;

3/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зориулалтын шаардлага хангасан шүүхийн байраар хангах хүртэлх хугацаанд нийслэл дэх зарим шүүхийг байраар хангаж, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

4/нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

5/Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн давж заалдах шатны шүүхийг тойргоор байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд



өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан байгууллагад зөвлөсүгэй:

1/шүүгчийн орон тооны хязгаарын саналыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөл /Л.Энхбилэг/-д;

2/Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан прокурорын байгууллагын орон тоо, төсөвт өөрчлөлт орох эсэхийг судлан үзэж, шаардлагатай бол саналаа боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэхийг Улсын ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/-т.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 06 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “26.Ургамал хамгааллын газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “26, 27, 28, 29” гэсэн дугаарыг “27, 28, 29, 30” гэж өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

